**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 сарын 14-ны өдөр Дугаар БА-009/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын B1, B2 давхар зоорьтой 262 (хоёр зуун жаран хоёр) автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 (хоёр зуун далан ес) орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолборын зориулалтай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 27-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/04/27 огноо, 0012614 дугаар, БАЗГ2023/174

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр:МИК-07/2023

2.3. Захиалагч: Саран-Өрх ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011280003 регистрийн дугаар, 5457688 Хаяг: Хан-Уул дүүрэг 18 хороо 4 С3 413 тоот холбоо барих утас 99998348 цахим хаяг saranurkhllc@gmail.com

Вертекс товер ХХК оноосон нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011850512 регистрийн дугаар, 8338604 Хаяг: Хан-Уул дүүрэг 19 хороо үйлдвэр ХД 66-19 тоот холбоо барих утас 99998348 цахим хаяг vertextowerllc@gmail.com

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: РЕООК ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011684124 регистрийн дугаар, 6254454 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ11-550/23 Хаяг: Баянгол дүүрэг 4-р хороо 2 хороолол Энхтайвны өргөн чөлөө 3-46 тоот холбоо барих утас,99112444 цахим хаяг reook@gmail.com

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Голден лайт групп ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011380136 регистрийн дугаар, 5659515 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, БУ12-896/20 Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 6-р хороо 13-р хороолол 63 байр 27 тоот холбоо барих утас: 88114590, цахим хаяг; goldenlightllc@gmail.com

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Мөнх-Инж констракшн ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011342038 регистрийн дугаар, 2819236 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, 3Т12-217/22 Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 3-р хороо 204 тоот холбоо барих утас, 99999955 цахим munkhinj@gmail.com

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Вертекс товер ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9011850512 регистрийн дугаар, 8338604 Хаяг: Хан-Уул дүүрэг 19 хороо үйлдвэр ХД 66-19 тоот холбоо барих утас 99998348 цахим хаяг vertextowerllc@gmail.com

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

☑ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын В1, В2 давхар зоорьтой 262 (хоёр зуун жаран хоёр) автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 (хоёр зуун далан ес) орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолборын зориулалттай барилга, байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:
Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:
   а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
   б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын В1, В2 давхар зоорьтой 262 (хоёр зуун жаран хоёр) автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 (хоёр зуун далан ес) орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолборын зориулалтай барилга,байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо,
Саран-Өрх ХХК, Вертекс товер ХХК-ийн захиалгатай,
5 блок, аялал жуулчлалын цогцолбор

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Саран өрх ХХК-ийн гүйцэтгэх захирал (А.Билгүүн)

Вертекс товер ХХК-ийн захирал (А.Билгүүн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 644
Огноо: 2025 он 09 сар 14 өдөр
Бүртгэсэн:
УЛААНБААТАР ХОТ ... №1584

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 23 ДУГААР ХОРОО, САРАН-ӨРХ ХХК, ВЕРТЕКС ТОВЕР ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, B1, B2 ДАВХАР ЗООРЬТОЙ 262 АВТОМАШИНЫ ХҮЧИН ЧАДАЛТАЙ 1 БЛОК НЭГДСЭН ДУЛААН ЗОГСООЛ, 2 ДАВХАР, 2 БЛОК, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР, 16 ДАВХАР, 2 БЛОК, ТҮР БУУДАЛЛАХ, ОТОГЛОХ, 279 ОРОН БАЙР, НИЙТ 5 БЛОК АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 27 Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Саран-Өрх ХХК, Вертекс товер ХХК-ийн захиалгатай, B1, B2 давхар зоорьтой 262 автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолбор барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 4-р давхрын 5-р өрөөнд 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 15⁰⁰ цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 18⁰⁰ цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Б.Батчимэг
2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч Саран өрх ХХК-ийн гүйцэтгэх захирал — А.Билгүүн
3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч — Г.Батбаатар
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч — Э.Цогзолмаа
5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн ШХХА-ны дарга — Д.Сүхбат
6. Нийслэл түгээх сүлжээ ХХК-ийн Борлуулалтын албаны дарга — Б.Энхбат
7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК — М.Жаргалан
8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер — Д.Болормаа
9. Онцгой байдлын ерөнхий газар Зураг хяналтын тасгийн дарга Дэд хурандаа — Б.Мягмаржав
10. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын ахлах архивч — Э.Шижиртуяа
11. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер — О.Ундрах
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл — Б.Даваасүрэн
13. ОСНААУГ, Хэрэглэгчид үйлчлэх төвийн ахлах — Э.Бат-Ундрал
14. Мөнх инж констрагшн ХХК-ийн архитектур — Э.Номт
15. Реоок ХХК-ийн захирал — Э.Энхтөр

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн -15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан –15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Саран-Өрх ХХК, Вертекс товер ХХК-ийн захиалгатай, B1, B2 давхар зоорьтой 262 автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолбор барилгыг ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Г.Батбаатар;**

- Гадна тохижилт хүүхдийн тоглоомын талбайг зураг төсөлд заасны дагуу хийх;
- E1, F1 блокийн заслын ажил бүрэн дуусгах;
- Гадна фассадны ажил бүрэн дуусгах;
- C1 хойноос орох хаалганд ХБИ зориулсан пандус хийх;
- Үйлчилгээний төвийн 00 өрөөнд тоноглол хийх;
- Дээврийн усны хаялага шүүр хийх;
- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрэн үзүүлэх;

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа;**

- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах;
- Дотор халаалтын угсарсан ил, далд акт шалгуулах;
- C1 блокийн 1 давхрын үйлчилгээний АС-г бүрэн дуусгах тухай баталгаа албан тоот ирүүлэх;

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн ШХХА-ны дарга **Д.Сүхбат;**

- Термостат винтель суурилуулах;

Нийслэл түгээх сүлжээ ХХК-ийн Борлуулалтын албаны дарга **Б.Энхбат;**

- Үүрэг даалгварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна;

ХЯНАЛТ
Барилга байгууд
оруул

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК **М.Жаргалан;**

- B1, B2 давхруудад болон гадна хяналтын камер суурилуулж фото зургаар баталгаажуулах;
- B1, B2 давхруудад зарлан мэдээлэх систем МИК-07/2023 зургийн дагуу суурилуулж гүйцэтгэлийн актаар баталгаажуулах;
- Давхрын самбаруудад хаяг бирк хийж фото зургаар баталгаажуулах;

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн албаны менежер **Д.Болормаа;**

- Нийслэлийн эрүүл мэндийн газарт ундны шинжилгээг өгч дүгнэлт гаргуулах;

- Ундны усны 75м3-н нөөцийн саванд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн актаар баталгаажуулах, техник ашиглалтын пасспорт хөтлөн байнгын ашиглалтыг хангах;
- УСУГ-тай байгуулсан цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах аж ахуйн гэрээг шинэчлэх;
- 180/23 тоот техникийн нөхцөлийн шаардлагын дагуу хос шугам сүлжээ татах, усан сан угсрах ажилд хамтран ажиллах, оролцох тухай баталгаа албан бичиг өгөх;

Онцгой байдлын ерөнхий газар, Зураг хяналтын тасгийн дарга Дэд хурандаа **Б.Мягмаржав;**

- Нэгдсэн зогсоолд гал унтраах автомат систем, гал түймрийн үеийн утаа зайлуулах, агаар өгөх системийн ажиллагааг шалгасан акт нөхөж үзүүлэх.
- Шатны хонгилд төлөвлөгдсөн хаалганд тоноглол хийх;
- Үйлчилгээний барилгын галын дохиолол, гал унтраах системийг дуусгах;

Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын ахлах архивч **Э.Шижиртуяа;**

- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товьёог үйлдэх;
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх;

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **О.Ундрах;**

- Бетоны бат бэхийн лабораторын дүгнэлтийг блок, давхар тус бүрээр нь нөхөж үзүүлэх
- Зураг төсөлд цонх 3 давхар шиллэгээтэй гэж заасан 2 давхраар хийсэн байна. Үүн дээр зохиогч байгууллага дулаан техникийн тооцоо хийж тайлбар албан тоот ирүүлэх;
- Дээврийн дотуур усны хаялага шүүр хийх;
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж, төлөх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл **Б.Даваасүрэн;**

- Гадна ХБИ-ны авто машины зогсоолд босоо тэмдэглэгээ хийх;
- Барилгын зүүн талын явган хүний замд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг хийх, хийгдсэн хөтөч замын эхлэл төгсгөл эргэлийг зөв болгох;
- Үйлчилгээний төвүүдийн гаднаас ордог бүх гарцанд налуу замыг стандартын дагуу хийх, хийгдсэн налуу замуудад 2 талдаа ижил бариул хийх, босго 2 см-с өндөргүй байх;
- Цахилгаан шатанд зарлан мэдээллэгч буюу давхар зарлагч суурилуулах
- Рампуудыг стандартын дагуу төлөвлөж хийх;
- Үйлчилгээний төвүүдийн АЦӨ-д ХБИ-ны орон зайг зөв төлөвлөж тусгай тоноглолоор тоноглох;
- Орцны налуу замын төгсгөлийг засах;
- Лифтнээс граж руу орох хэсгийн босгонд пандус хийх С1 блокийн доорх;

ОСНААУГ ХҮТ-ийн ахлах инженер **Э.Бат-Ундрал;**

- Дээд доод бүсийн холигч узель, техникийн давхар хэвтээ магистралд шугамын хаягжуулалт хийх;
- Холигч узель удирдлагын самбарт ECL-110 контреллер, халаалтын насос бүрэн автомат горимд тохируулга хийж ажиллагаанд оруулах;

- Гадна бохирын худагт хүн орж үйлчилгээ үзүүлэх нөхцөл хангах;
- Холигч узель техникийн давхарт ус зайлуулах трап, суваг хийх;
- Холигч узелийн удирдлагын самбарт цахилгааны засвар үйлчилгээ үзүүлэхэд төвөгшилтэй буюу хэт өндөрт байрлуулсан байгааг цаашид анхаарах;
- Барилгын ашиглалт үйлчилгээг ОСНААУГ-т хүлээлгэн өгөх

Зураг төсөл зохиогч "Мөнх инж констракшн" ХХ-ийн архитектур **Э.Номт;**
- Үүрэг даалгварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна;

Комиссын дарга: Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгааг албан бичгээр ирүүлэх;
- БНбД 11-04-16 дагуу зохиогчийн нэгдсэн дүгнэлт шинэлчлэн ирүүлэх;
- Тагтны шилэнд нарны гэрэл буурүүлах зориулалттай шил ашигласан, айлын хаалганы онгойлт мөргөлдөж байгаад зохиогчоос тайлбар ирүүлэх;
- Өөрчлөгдсөн ажлыг (зураг төслөөс) баталгаажуулж ирүүлэх;
- Айлын зочны өрөөний цонхонд төмөр хайс хашлага хийх;
- Орцны шилэн хаалга, хананд хамгаалалтын хуулга наах;
- Барилгын ажил үргэлжилж буй А блок барилгад "Барилга замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага" заасны дагуу арга хэмжээ авах;

Гүйцэтгэгч байгууллага "Реоок" ХХК-ийн захирал **Э.Энхтөр;**
- Үүрэг даалгварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна;

Гүйцэтгэгч байгууллага "Вертекс товер" ХХК-ийн захирал **А.Билгүүн;**
- Үүрэг даалгварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Саран-Өрх ХХК, Вертекс товер ХХК-ийн захиалгатай, В1, В2 давхар зоорьтой 262 автомашины хүчин чадалтай 1 блок нэгдсэн дулаан зогсоол, 2 давхар, 2 блок, аялал жуулчлалын цогцолбор, 16 давхар, 2 блок, түр буудаллах, отоглох, 279 орон байр, нийт 5 блок аялал жуулчлалын цогцолбор барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:
Саран өрх ХХК-ийн гүйцэтгэх захирал (А.Билгүүн)

Вертекс товер ХХК-ийн захирал (А.Билгүүн)